



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/707

Арвайхээр

┌ Комисс томилох, үнэ тогтоох тухай ┐

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 9.1, 9.2 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.


Комиссын дарга: Ц.Хашхүү -Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга  
Дуудлага худалдааны хөтлөгч: Г.Дуламдорж -Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн  
Тэмдэглэл хөтлөгч: Л.Дүүмаа -Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн  
Гишүүн: Б.Дэлгэрмаа -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

2. Комиссын дарга (Ц.Хашхүү)-д ДААЛГАХ нь:

а. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны өсгөх үнийн доод хязгаарыг 100000 (нэг зуун мянга) төгрөг дээд хязгаарыг 500000 (таван зуун мянга) төгрөг байхаар тогтоон, зохих журмын дагуу дуудлага худалдааг зохион байгуулах.

б. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101345